“ЛИМИТЭД ЭКО ПРОТЕКТ” ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 5-Р ХОРООНД БАЙРЛАХ, “УНДРАХ ГАРЦ” ХХК-Н ХИМИЙН БОДИС, ИМПОРТЛОХ ХАДГАЛАХ, ХУДАЛДААЛАХ,ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

“ЛИМИТЭД ЭКО ПРОТЕКТ” ХХК

ЗАХИАЛАГЧ:

“УНДРАХ ГАРЦ ”ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 7-р хороо, 11-р хороолол Их тойруу 82, Одкон холдинг 309 тоот, Утас: 99296506, 88061782

2026 ОН

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 4

..... 5

1.1 Төслийн хүчин чадал 5

Төслийн хүрээнд ашиглагдах химийн бодисын хэрэглээ, зориулалт, хэмжээ: 6

1.2 Төслийн талбайн өнөөгийн байдал 12

1.3 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал: 16

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 16

2.1 Уур амьсгал 16

2.2 Геологийн тогтоц ба геоморфологи 16

2.3 Гадаргын ус 17

2.4 Хөрсөн бүрхэвч 17

2.5 Ургамлан бүрхэвч 18

2.6 Амьтны аймаг 18

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 19

3.1 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл 21

3.2 Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга 22

хэмжээний зөвлөмж 22

3.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл 22

3.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл 23

3.5 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл 23

3.6 Хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны үед үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ 23

3.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ 24

3.8 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж 24

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ 25

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 26

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 29

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 29

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 30

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 31

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 32

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 33

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 34

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга.....4
Хүснэгт 2. Ажилчдын хүн хүчний тооцоо 5
Хүснэгт 3. Ажиллагчдын мэргэжлийн ур чадварын тодорхойлолтын хүснэгт.....5
Хүснэгт 4. Цалингийн зардлын тооцоо 6
Хүснэгт 5. Зардлын тооцоо.....6
Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн тооцоо. 6
Хүснэгт 7. Төсөлд ашиглагдах химийн бодисуудын нэр, томъёо болон бусад мэдээлэл 7
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ.....19
Хүснэгт 9.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн 25
Хүснэгт 10. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө 26
Хүснэгт 11.Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 29
Хүснэгт 12.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 29
Хүснэгт 13. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө.....30
Хүснэгт 14. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө.....31
Хүснэгт 15. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө 32
Хүснэгт 16. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 33
Хүснэгт 17. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....34

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төслийн байршлын зураг 5
Зураг 2. Химийн бодисын агуулах, хамгаалалтын хашаа татсан байдал.....13
Зураг 3. Химийн бодисын агуулахын гадна талбай, орц, гарцын хаалга.....13
Зураг 4. Агуулахын дээвэр болон гэрэлтүүлгийн хэсэг 14
Зураг 5. Агуулахын хана, шал, цахилгааны эх үүсвэр.....14
Зураг 6. Агуулахын гадна байрлах галын хэрэгсэл болон тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал 14
Зураг 7. Агуулахын дотор байрлах галын хэрэгсэл 15
Зураг 8. Агуулахын дотор байрлуулсан тэмдэг тэмдэглэгээ, асгаралтын иж бүрдэлүүд.....15

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Ундрах гарц” ХХК нь 2019 оноос эхлэн Уул уурхай, барилга болон хүнсний салбарт үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан химийн хортой болон аюултай бодис нэгдлүүдийг тогтвортой, баталгаатай, хариуцлагатай ханган нийлүүлэгч болон үйл ажиллагаагаа явуулсан ирсэн байна. Энэ цагаас эхлэн химийн хортой болон аюултай бодис нэгдлүүдтэй харьцах, тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд сайтар ханган ажилласны үр дүнд өөрийн эзэмшлийн химийн бодисын агуулахыг стандартын шаардлага хангасан байршилд, барилга байгууламж болон бусад нөхцлийг дүрэм, журмын дагуу нэг бүрчлэн ханган биелүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

Төсөл хэрэгжүүлэгч химийн бодисуудаас бүтээгдэхүүний зориулалт, хэрэглээ, тоо хэмжээ, техникийн шаардлага, бүтээгдэхүүн худалдан авалт нийлүүлэлт, цаг хугацаа, улирал гэх мэт олон хүчин зүйлийг үндэслэн жилд 2-4 удаагийн таталтаар 32 нэр төрлийн бодис нэгдлүүдийг импортлон оруулж ирж, нөөцлөн хадгалж захиалагч болон худалдан авагч нарт нийлүүлэхээр ажиллаж байсан бол хүчин чадлаа нэмэгдүүлэн 140 нэр төрлийн бодисын импортлон тогтвортой, найдвартай ханган нийлүүлэгч болохоор төлөвлөн зорилго тавин ажиллаж байна.

Засаг даргын 2022/12/27-ны өдрийн А/381 тоот шийдвэрийг үндэслэн олгосон, нэгж талбарын 1260510423 дугаартай, 1000 м.кв эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулахаар өөрсдийн химийн бодисын агуулахыг 2022 онд ашиглалтад оруулсан. Гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх салхивчтай, Агуулахын хана, шал нь химийн бодисоос үүссэн тоос, уур манан тогтохооргүй материалаар хийгдсэн, 24 цагийн турш харуул хамгаалалттай болно. Химийн бодис хадгалах агуулах нь “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 10 дугаар зүйлд заасан химийн бодис хадгалахад тавигдах үндсэн шаардлага, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх ашиглах, устгах журмын 3.2.1.6-д заагдсан шаардлага, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS6458:2016 стандартад нийцсэн агуулах болно.

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:	**“Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах”**
Төсөл хэрэгжүүлэгч:	“Ундрах гарц” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011518010
Регистрийн дугаар:	5903017
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	УБ, ХУД, 15-р хороо, ***М***ахатма ганди 59-35 тоот
Утас:	976-96166666
Төслийн байршил:	Монгол улс, Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 5-р хороо



Зураг 1.Төслийн байршлын зураг

1.1 Төслийн хүчин чадал

Төсөл хэрэгжүүлэгч нь 2019 оноос эхлэн энэ салбарт тогтвортой үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд үйл ажиллагаандаа түрээсийн агуулахыг ашигласаар ирсэн. Сүүлийн жилүүдэд хариуцлагатай, найдвартай ханган нийлүүлэгч байж үйл ажиллагаагаа тогтвортой явуулсны үр дүнд өөрийн эзэмшлийн химийн бодисын агуулахыг стандартын шаардлага хангасан байршилд, барилга байгууламжийг барьж байгуулан үйл ажиллагаагаа өртгөтгөн, хүчин чадлаа нэмэгдүүлэн ажиллах зорилго тавин ажиллаж байна.

Хүснэгт 2. Ажилчдын хүн хүчний тооцоо

№	Жагсаалт	Ажиллах хүний тоо	Ажиллах сар	Цалин олгох хэлбэр
	А. Удирдах ажилтан			
1	Ерөнхий захирал	1	12	Цагаар олгох цалин
2	Менежер	1	12	Цагаар олгох цалин
3	Нягтлан бодогч	1	12	Цагаар олгох цалин
4	Ерөнхий технологич	1	12	Цагаар олгох цалин
5	Туслах технологич	1	12	Цагаар олгох цалин
6	Манаач	3	12	Цагаар олгох цалин
7	Түр ажилчид	-	-	Хийснээр
	Дүн	8	96	

Хүснэгт 3. Ажиллагчдын мэргэжлийн ур чадварын тодорхойлолтын хүснэгт

№	Ажилтан	Мэргэжлийн ур чадварын тодорхойлолт

1	Ерөнхий химич	Химич мэргэжилтэй, дээд боловсролтой, 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай, химийн бодис нэгдлүүдтэй харьцан ажиллах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг хариуцан ажиллах, аюултай хог хаягдлын тоо хэмжээ, хадгалалт хамгаалалтыг зохистой хэм хэмжээнд, хүрээлэн буй орчинд хор нөлөөгүй байх нөхцөлий г бүрдүүлэн ажиллана.
2	Туслах химич	Химич мэргэжилтэй, дээд боловсролтой, агуулахын ойр орчим болон хог хаягдал, хөрс, ургамал, амьтан, төслийн талбайн экологийн аюулгүй байдлыг ханган ажиллана.
3	Менежер	Дээд боловсролтой, хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай, түргэн шуурхай, үнэнч, найдвартай.
4	Нягтлан бодогч	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн дээд мэргэжилтэй, тайлан бланс гарган, багаар ажиллах чадвартай, дүн бүртгэлийг сайтар хийдэг байх.
5	Манаач	Багаар ажиллах чадвартай,бүртгэл тооцооны болоод харуул хамгаалалтын зохих дадлага туршлагатай, үнэнч шударга байх
6	Түр ажилчид	Түргэн шуурхай ажиллах чадвартай, даалгасан ажлыг эмх цэгцтэй хийдэг, багаар ажиллах чадвартай

Хүснэгт 4. Цалингийн зардлын тооцоо

	Удирдах ажилтан	Ажиллах хүний тоо	Ажиллах сар	Сарын цалин, мянган төгрөг	Жилийн цалингийн сан, мянган төгрөг
1	Гүйцэтгэх захирал	1	12	1.800.000	21.600.000
2	Ерөнхий технологич	1	12	1.500.000	18.000.000
3	Туслах технологич	1	12	1.200.000	14.400.000
4	Менежер	1	12	1.300.000	15.600.000
5	Нягтлан бодогч	1	12	1.300.000	15.600.000
6	Манаач	3	12	600.000 х 3	21.600.000
Дүн		8	96	8.900.000	**106.800.000**

Хүснэгт 5. Зардлын тооцоо.

№	Зардлууд	Сар
1	Түрээс	2.500.000
2	Цахилгаан	800.000
3	Ус	Гүний худгаас зөөврөөр
4	Халаалт	Тогоор
5	Цэвэрлэгээ	100.000
6	Хөдөлмөр хамгаалал	300.000
7	Хоол	700.000
8	Бичиг хэрэг	100.000
9	Бусад зардал	500.000
	Нийт	**5.000.000**

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн тооцоо.

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт өртөг, мянган төгрөг
1	20тн контайнер оффис болгон тохижуулсан	1	-	15.000.000
2	1тн усны сав	2	1.000.000	2.000.000
3	Химийн бодис агуулах тохижуулахад	1	-	24.000.000
4	Агуулах халаах халаагуур	16	500.000	13.000.000
5	Оффисын тавилга, цахилгаан хэрэгсэл	-	-	5.000.000
Дүн				**59.000.000**

Төслийн хүрээнд ашиглагдах химийн бодисын хэрэглээ, зориулалт, хэмжээ:

Засаг даргын 2022/12/27-ны өдрийн А/381 тоот шийдвэрийг үндэслэн олгосон, нэгж талбарын 1260510423 дугаартай, 1000 м.кв эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулахаар өөрсдийн химийн бодисын агуулахыг 2022 онд ашиглалтад оруулсан.

Төслийн хүрээнд нийт 140-н нэр төрлийн химийн хорт болон аюултай бодисуудыг түнш ААН-дэд тогтвортой ханган нийлүүлэх зорилготойгоор импортон худалдан борлуулах бөгөөд үүнээс 107 нэр төрлийн бодис нэгдлүүдийг уул уурхай, барилга болон хүнсний үйлдвэрлэлийн салбарт харин 33 нэр төрлийн бодис, нэгдлүүдийг ХАА-н салбарт ургамал хамгааллын зориулалтаар ашиглахаар төлөвлөжээ. Химийн бодис нэгдлүүдийн тоо ширхэг, олон улсын нэр, олон улсын дугаар, томьёо болон хэмжээг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй үзүүлж, жилд хэрэглэгдэх хэмжээг 5 жилээр тооцоолон тусган орууллаа.

Хүснэгт 7. Төсөлд ашиглагдах химийн бодисуудын нэр, томьёо болон бусад мэдээлэл

№	Монгол нэр	Олон улсын нэр	Томъёо	CAS дугаар	Хүссэн (тн)
Уул уурхай болон үйлдвэрийн зориулалтаар ашиглагдах бодис, нэгдлүүд					
1.	Этиленгликоль	Ethylene glycol 1,2-Ethanediol	C2H6O2	107-21-1	340
2.	Тиомочевин	Thiourea	(NH2)2CS	62-56-6	180
3.	Цууны хүчил	Acetic acid	CH3COOH	64-19-7	380
4.	Натрийн нитрит	Sodium nitrite	NaNO2	7632-00-0	240
5.	Хөнгөн цагааны сульфат	Sulfuric acid, aluminum salt	Al2(SO4)3x18H2O	10043-01-3	120
6.	Магнийн хлорид	Magnesium chloride	MgCl2 x 6H2O	7791-18-6	100
7.	Аммиак	Ammonium hydroxide	NH4OH	1336-21-6	70
8.	Натрийн гидроксид	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	500
9.	Натрийн карбонат	Sodium carbonate	Na2CO3	497-19-8	420
10.	Устөрөгчийн хэт исэл	Hydrogen peroxde	H2O2	7722-84-1	420
11.	Фосфорын хүчил	Phosphoric acid	H3PO4	7664-38-2	90
12.	Давсны хүчил	Hydrochloric acid	HCl	7647-01-0	400
13.	Азотын хүчил	Nitric acid	HNO3	7697-37-2	280
14.	Полиалюминий хлорид	Poly Aluminium Chloride	Al2Cln(OH)6-n	1327-41-9	220
15.	Натрийн фосфат	Trisodium phosphate	Na3PO4 x12H2O	10101-89-0	100
16.	Полиакриламид	PAM	(C3H5NO)n	9003-05-8	140
17.	Цардуул	Starch soluble	[C6H10O5]n	9005-25-8	220
18.	Тосны хүчил	Oleic acid	C18H34O2	112-80-1	820
19.	Шингэн шил	Sodium silicate	Na2SiO3	6834-92-0	780
20.	Хлорын шохой	Calcium hypochlorite	Ca(ClO)2	7778-54-3	150
21.	Гидразин гидрат	Hydrazine hudrate	N2H4	7803-57-8	18
22.	Калийн перманганат	Potassium permanganate	KMnO4	7722-64-7	30
23.	Моноэтаноламин	Monoethanolamine	C2H7NO	141-43-5	30
24.	Хлорт кальци	Calcium chloride	CaCl2·2H2O	10035-04-8	50
25.	Борын хүчил	Boric acid	H3BO3	10043-35-3	80
26.	Цайр нунтаг	Zinc	Zn	7440-66-6	320
27.	Катионит Ку-2	Ion exchange resins	***	***	150
28.	Гипохлорид натри	Sodium hypochlorite	NaClO	7681-52-9	120
29.	Магнийн нитрат	Magnesium nitrate	Mg(NO3)2	13446-18-9	50
30.	Кальцийн нитрат	Calcium nitrate	Ca(NO3)2	10124-37-5	50
31.	Төмрийн сульфат	Ferric sulfate	FeSO4·7H2O	7720-78-7	50
32.	Төмрийн сульфат	Ferric sulfate	Fe2(SO4)3	1310-73-2	50

33.	Зэсийн сульфат	Copper sulphate	CuSO4·5H2O	7758-99-8	300
34.	Метабисульфит натри	Sodium metabisulphite	Na2S2O5	7681-57-4	300
35.	Цахиурын исэл	Silicon monoxide	SiO2	7631-86-9	300
36.	Бор хүчлийн натри	sodium tetraborate	Na2B4O7·10H2O	1330-43-4	300
37.	Хүхрийн хүчил	Sulphuric acid	H2SO4	7664-93-9	700
38.	Сульфамикийн хүчил	Sulphamic acid	H3NSO3	5329-14-6	25
39.	Антискалант	Antiscalant	Antiprex 11	-	80
40.	Сольвент	Solvent oil Solvent		64742-48-9	40
41.	Мочевин	Urea	CH4N2O	57-13-6	780
42.	Натрийн нитрат	Sodium nitrate	NaNO3	7631-99-4	150
43.	Хлорт хөнгөнцагаан	Aluminium chloride	AlCl3	7446-70-0	100
44.	Метил изобутил carbinol	Methyl isobutyl carbinol	C6H14O	108-11-2	1000
45.	Лимонны хүчил	Citric acid	C6H8O7	77-92-9	100
46.	Хүхэрт натри	Sodium sulfide	Na2S	1313-82-2	270
47.	Кобальтын сульфат	Cobalt(II) sulfate	CoSO4·(H2O)n (n=0,1,6,7)	10124-43-3 13455-34-0 (monohydrate) 10026-24-1 (heptahydrate)	20
48.	Кварцан элс	Quiartz stand	***	***	50
49.	Натрийн сульфат	Sodium sulfate	Na2SO4	7757-82-6	60
50.	Натрийн бутил ксантат	Sodium butyl xanthate	C5H9Na2OS2	141-33-3	100
51.	Аммонийн сульфат	Ammonium sulfate	(NH4)2SO4	7783-20-2	75
52.	Силика гель	Silica gel	SiO2	112926-00-8	30
53.	X-133	Oreprep X-133 EU Frother	***	***	
54.	Анионит	Ion exchange resin	***		50
55.	Цеолит	Zeolites	***		10
56.	Шоргоолжны хүчил	Formic acid	CH2O2	64-18-6	30
57.	Никелийн сульфат	Nickel(II) sulfate	NiSO4	7786-81-4 (anhydrous) 10101-97-0 (hexahydrate) 10101-98-1 (heptahydrate)	25
58.	Бисульфид натри	Sodium bisulfite	NaHSO3	7631-90-5	2
59.	Кали иод	Potassium iodide	KI	7681-11-0	2
60.	Калийн суурь	Potassium hydroxide	KOH	1310-58-3	70
61.	Бетоны ус багасгагч бодис	50% polycarboxylate superplasticizer /water reducing type/	Нийлмэл бодис	27599-56-0	200
62.	Бетоны өтгөрөлт удаашруулагч бодис	50% polycarboxylate superplasticizer /slump retention type/	Нийлмэл бодис	27599-56-0	300
63.	Бетоны уян налархайжуулагч бодис	Sodium gluconate	C6H11NaO7	527-07-1	40
64.	Бетоны агааржуулагч бодис	Air Entraining Agent	RO(CH2CH2O)nSO3NaR:C112-15 alkyl N:2-3	68585-34-2 9004-82-4	3
65.	Хүйтэн	No chloride	HO-CH2-CHOH-CH3	57-55-6	150

	эсэргүүцэгч нэмэлт шингэн	Antifreeze 1 2-propanediol			
66.	Бетоны ус тусгаарлагч бодис	Watertroof admix	C5H12O7	526-95-4 133-42-6	30
67.	Бетоны түргэн бэхжүүлэгч бодис	Concrete accelerator	C6H12O7*H2O	526-95-4	30
68.	Ус багасгагч нэмэлт GK-3000	Water Reducer GK-3000	(C16H14O3)N	24936-68-3	1200
69.	Бетоны хөлдөлтөөс сэргийлэх нэмэлт GK-20	Anti-freezing pumping agent GK-2B	Al2O12S3	10043-01-3	500
70.	Бетонд агаар оруулах нэмэлт GK-9A	Air entraining agent GK-9A	***	102-71-6 1310-73-2	50
71.	Бетоны хөдөлгөөнд чадварыг хадгалах нэмэлт SR-1	Slump retention agent SR1	(C16H14O3)N	24936-68-3	1200
72.	Бетоны хөдөлгөөнд чадварыг хадгалах нэмэлт SR-2	Slump retention agent SR2	C6H11NaO7	527-07-1	500
73.	Бетоны хөдөлгөөнд чадварыг хадгалах нэмэлт SR-3	Slump retention agent SR3	C20H24CaO10S2	8061-52-7	500
74.	Бетоны бэхжилтийг хурдасгагч нэмэлт GK-3B	Accelerator GK3B	***	10043-01-03	500
75.	Бетоны бэхжилтийг хурдасгагч нанокристалл мөхлөг GK-3Z	Nanocrystaline seed strength accerator GK3Z	O2Si	7631-86-9	200
76.	Бетоны унжрамтгай чадварыг сайжруулах нэмэлт (VMA) GK-B3	Concrete viscosity modifier agent (VMA) GKB3	C10H9NO3S	81-05-0	200
77.	Хэвийн тосолгооны тос	Deform oil agent	***	62601-60-9	300
78.	Бетоны бэхжилтийг удаашруулагч нэмэлт GK-4A	GK-4A Retarder	C20H24CaO10S2	8061-52-7	500
79.	Ус багасгагч нэмэлт GKA	Efficient superplasticizer GK-A	C10H8	91-20-3	800
80.	Ус тусгаарлах GK-6A	GK-6A waterproof agent	C9H11NaO4S	70788-40-8	500
81.	Гидратацийн дулааныг зохицуулах нэмэлт GK-4Z	Inhibitor of hydration heat GK-4Z	C12H19ClN4O7P2S	154-87-0	500
82.	Зэврэлтийн эсрэг	Antiseptic and	***	10588-01-9	200

	нэмэлт GK-6B	anticorrosion agent GK-6B			
83.	Шаварлаг агууламж ихтэй бетоны нэмэлт GK-Z	Concrete antimud agent GK-Z	***	63148-62-9	100
84.	Силикофум	Silica fume	SiO2	69012-64-2	5000
85.	Бетоны усанд угаалтаас сэргийлэх нэмэлт	Anti washout admix	***	69012-64-2	200
86.	Хөөсрөлтийн эсрэг нэмэлт	Antifoam	(R2R*SiO)2	***	5
87.	Фенол формальдегид Резин	Phenol Formaldehyde Resin PF 8593 FL-Bakelite	C8H6O2	***	5
88.	Нэмэлт (AD нунтаг)	Steel making accelerator (AD powder)	***	***	20
89.	Хөнгөнцагааны оксид	Aluminum oxide	Al2O3	1302-74-5	60
90.	Натрийн фторт хөнгөнцагаан	Sodium fluoroaluminate	AlF4Na	13821-15-3	10
91.	Натрийн ортофосфат	Sodium orthophosphate	NaH2PO4	7558-80-7	5
92.	Нэмэлтийн (перпит ценосфер)	Perfite Cenosphere	***	***	35
93.	Хөнгөнцагааны нунтаг	Aluminium powder	Al	7429-90-5	60
94.	Бетон зуурмагийн нэмэлт / ЕОА төрлүүд/	High efficience water reducer /Polycarboxylic acid/ water reducing type	***	***	300
95.	Бетон зуурмагийн нэмэлт	High efficience water reducer /Polycarboxylic acid/ slump loss	***	***	300
96.	Натрийн этоксид	Sodium ethoxide	C2H5NaO	77-09-8	30
97.	Натрийн лаурил сульфат	Sodium lauryl sulfate	C12H25NaO4S	151-21-3	5
98.	Натрийн глюконат	Sodium gluconate	CH2OH(CHOH)4COONa	527-07-1	100
99.	Битумын эмульгатор	Bitumen emulsifier	C24H54Cl2N2O	***	2
100.	Гидро Х	Hydro-x	***	***	40
101.	Идэвхжүүлсэн нүүрс	Activated carbon	***	7647-14-5	30
102.	Перхлорэтилен	Perchloroethylene	C2Cl4	127-18-4	60
103.	Мазут			ГОСТ 10585-2013	300
104.	Манганы сульфат	Manganese(II) sulfate	MnSO4	7785-87-7 10034-96-5 10101-68-5	250
105.	Натри хлор	Sodium chloride	NaCl	7647-14-5	500
106.	Антрацит	Anthracite			100
107.	Lix				
ХАА-н зориулалтаар ашиглагдах ургамал хамгааллын бодис, нэгдлүүд					
108.	Хаг хурдас удаашруулагч	MAS208	***	***	100
109.	Хлорт цайр	Zinc chloride	ZnCl2	7646-85-7	10

				Anhydrous	
110.	Тетрабромэтан	Tetrabromoethane	C2H2Br4	79-27-6	5
111.	Керосин	Kerosene	***	8008-20-6	240
112.	Ликс 674	LIX® 674N-LV, Solvent Extraction	***	***	240
113.	Аерофин-3418А	Aerophine 3418A	***	***	30
114.	Флокулянт	Flocculant	***	***	
115.	Тебүфенозид 240SC Мимик240SC	Tebufenozide	C22H28N2O2	112410-23-8	210
116.	Пумасупер, ЭМВ Овсюген Экспресс, КЭ, Фурэкс, КЭ, Ластик экстра, КЭ, Фенсок, EW	Fenoxaprop-P-ethyl	C16H12ClNO5	71283-80-2	210
117.	Глифосат, Раундал ВР, Спрут экстра ВР, Торнадо, Глиомекс ВР	Glyphosate	C3H8NO5P	1071-83-6	850
118.	Циприн, Циперметрин, бодист цис, транс	Cypermethrin	C22H19Cl2NO3	52315-07-8	100
119.	Децис, Децимон	Deltamethrin	C22H19Br2NO3	52918-63-5	200
120.	Матрин	Matrine	C15H24N2O	519-02-8	280
121.	Тиаклоприд	Thiacloprid	C10H9ClN4S	111988-49-9	200
122.	Каратэ, МКС, ЕС Каратокс, Брейк, МЭ Самум КЭ, Молния КЭ	Lambda-cyhalothrin	C23H19ClF3NO3	91465-08-6	600
123.	Зингер, СП, Алмазис ВДГ , Магнум ВДГ	Metsulfuron-methyl	C14H15N5O6S	74223-64-6	30
124.	Сумицидин Сумипланта	Fenvalerate	C25H22ClNO3	51630-58-1	150
125.	Пурестар	Глифосат сафлуфенацил	C3H9 C3H9 C3H8NO5P	338641-94-0 372137-35-4	50
126.	Клоквинтосет-мексил Ластик экстра, КЭ	Cloquintocet-mexyl	C18H22ClNO3	99607-70-2	70
127.	Балерина СЭ, Балерина супер СЭ	Florasulam	C12H8F3N5SO	145701-23-1	40
128.	Фенсок, EW Феноксапрон- П-этил, Феноксоп 100 КЭ, Тайгер 100 КЭ	Fenoxaprop-P	C16H12ClNO5	113158-40-0	70
129.	Дротик ККР	2 4-d 2- ethylhexyl ester	C16H22Cl2O3	1928-43-4	200
130.	Дротик ККР	2,4-D butyl ester	C12H14Cl2O4	94-80-4	200
131.	ВСК Колосаль КЭ, Бункер, Тебу 60, МЭ, Виал траст, ВСК, Гранберг КЭ, Фолмекс	Tebuconazole	C16H22ClN3O	107534-96-3 148-79-8	170
132.	Фосфорын бордоо	Двойной суперфосфат	Ca(H2PO4)2	****	700

	Фосфорын исэл (P2O5) 42-46%				
133.	Калийн бордоо Калийн исэл (K2O) 60-62%	Potassium chloride	KCl	****	400
134.	Аммонийн фосфат Азот (N) 18-21% Фосфорын исэл (P2O5) 46-53%	DAP- Diammonium Phosphate	(NH4)2HPO4	****	200
135.	Моно аммонийн фосфат Азот (N) 11-18% Фосфорын исэл (P2O5) 48-55%	MAP- Diammonium Phosphate	NH4H2PO4	****	200
136.	Нийлмэл бордоо	NPK-Complex fertilizer	N, P2O5, K2O	****	1000
137.	Аммофос	Азот- 12% , Фосфор- 52%	N, P2O5	****	80
138.	Амко- үр тариа	Нийлмэл бордоо	MgO, Mn, Cu	****	150
139.	Амко- төмс	Нийлмэл бордоо	NO3, NH4, NH4NO3, P2O5, K2O, SO3	****	150
140.	Форвард Хизалофоп-П-этил	Quizalofop-p-ethyl	C19H17ClN2O4	100646-51-3	200

Төслийн химийн бодисын агуулах:

“Ундрах гарц” ХХК нь Налайх дүүргийн засаг даргын 2022/12/27-ны өдрийн А/381 тоот шийдвэрийг үндэслэн олгосон, нэгж талбарын 1260510423 дугаартай, 1000 м.кв эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулахаар өөрсдийн хөрөнгөөр химийн бодисын агуулахыг барьж эхлэн химийн бодисын агуулахын барилга байгууламжий н стандарт шаардлагыг хангасан агуулахын барилгыг барьж байгуулан 2022 онд ашиглалтад оруулж, 2022.06.23-ны №02-06-040/581 дугаартай мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлттэй химийн бодисын агуулахыг ашиглалтад оруулаад байна.

Агуулах нь 1 давхар, зоорьгүй, 2 тасалгаатай, 375м2 талбайтай, сэндвичэн хийцтэй, орц, гарын хэсэгтэй, шал нь бетон хийцтэй, галын сараа, тэмдэг тэмдэглээ, хамгаалах хувцас хэрэгсэл зэргийг бүрэн байршуулсан байна. Агуулах нь механик агааржуулалттай, тасалгаа бүрт агааржуулалттай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, 24 цагийн харуул хамгаалалттай, гадуураа 2,8м өндөр бетон хашаатай, гаднаас бүрэн тусгаарлагдсан агуулах байна.

1.2 Төслийн талбайн өнөөгийн байдал

Төслийн 2026 борлуулах химийн бодисын жагсаалт

№	Монгол нэр	Олон улсын нэр	Томъёо	CAS дугаар	Хүссэн (тн)
1	Цууны хүчил	Acetic acid	CH3COOH	64-19-7	18,7
2	Натрийн нитрит	Sodium nitrite	NaNO2	7632-00-0	28
3	Тиомочевин	Thiourea	(NH2)2CS	62-56-6	28
4	Мочевин	Urea	CH4N2O	57-13-6	240



Зураг 2. Химийн бодисын агуулах, хамгаалалтын хашаа татсан байдал



Зураг 3. Химийн бодисын агуулахын гадна талбай, орц, гарцын хаалга




Зураг 4. Агуулахын дээвэр болон гэрэлтүүлгийн хэсэг



Зураг 5. Агуулахын хана, шал, цахилгааны эх үүсвэр



Зураг 6. Агуулахын гадна байрлах галын хэрэгсэл болон тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал



Зураг 7. Агуулахын дотор байрлах галын хэрэгсэл



Зураг 8. Агуулахын дотор байрлуулсан тэмдэг тэмдэглэгээ, асгаралтын иж бүрдэлүүд

1.3 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал:

Цахилгаан: Техникийн нөхцөлийг- "Баясгалант Өргөө Констракшн" ХХК зөвшөөрлийн бичгийн дагуу, 35/6-ын Элстэй дэд станцын 6 кВ-н Городок фидерийн КТПН-7461 дэд өртөөний 0.4 кВ талаас төмөр бетон тулгуур бүхий бүрээстэй агаарын шугам кабель татаж тэжээсэн.

Ус: Ойр байрлах гүний худгаас зөөврөөр хангана.

Зам: Налайх дүүргээс 13 км зайтай.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Уур амьсгал

Уг төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрийн гадаргуугийн өвөрмөц нөхцөл бүс нутгийн уур амьсгал бүрэлдэн тогтох нэгэн хүчин зүйл болдог. Өөрөөр хэлбэл Хан Хэнтийн нурууны их уулс нь Монгол орны төрдийгүй Төв Азийн уур амьсгал бүрэлдэхэд Сибирээс их говь руу өөрөөр хэлбэл уртгагийн дагуу түрж тогтсон байна. Хан Хэнтийн нурууны байгалийн чиглэлийн судалгаа, уур амьсгалын ерөнхий тодорхойлолт хийгдсэн. Гэвч нарийвчилсан судалгаа хомс байна. Харин Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар байгуулагдсанаас хойших хугацаанд судалгаа өргөжиж байгаль орчин зүйн ажиглалтыг нилээд өргөн хүрээтэй, байгаль хамгаалагчдын нэгэн ажил болгож байгаа нь судалгааны суурь болж байна.

Хан Хэнтийн нурууг тойрон байгуулсан цаг уурын станц, харуулын олон жилийн баялаг мэдээлэл, ялангуяа Тэрэлж, Мөнгөнморьт, Хүрэлтогоот зэрэг станцуудын цаг уурын мэдээ сэлтийг хэрэглэв. Горхи - Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нэг тэгш хэмийн хуваарилалттай. Жилийн 4 улирлын өнгө алаглан ээлжлэн солигдож тод илэрдэг. Хаврын дулааралт намрын сэрүүсэлтийн явц ижилхэн зун нь сэрүүн чийглэг, өвөл нь хүйтэн чийглэг, уур амьсгалын үзүүлэлт нь хэм тэнцүү хуваарилалтай. Монгол орны бусад нутгаас хамгийн их хур тунадастай, чийглэг, сэрүүн өвөл нь цасархаг харьцангуй дулаавтар тунгалаг цэнгэг агаартай. Хавар нь хуурайвтар, хахир хахирлаг, намар нь өгөөж баян сэрүүн сэрүүвтэр, үе үе хөрөлтийн буюу цацрагийн манан, хүдэн татаж байдаг.

2.2 Геологийн тогтоц ба геоморфологи

Хэнтий нуруу нь геологийн тогтцын хувьд нилээд цомхон боловч өвөрмөц дүр төрхтэй. Хэнтий нуруунд анх төрмөл, эрт төрмөл, дунд төрмөлийн эриний настай гүний болон тунамал чулуулаг тархсан байна. Эрт төрмөлийн чулуун нүүрсний галавын нүүрст ба

нүүрстөрөгчит шаварлаг занар, Туул, Заан голуудын эхэн сав газраар, девоны ангилагдаагүй чулуулаг, цахиурлаг занар, хас, нүүрст ба нүүрстөрөгчит шаварлаг занар зэрэг чулуулаг Өвөр Минж, Туулын эх, Тэрэлжийн сав газраар тархсан байна. Хөрс үүсгэгч дөрөвдөгчийн аллюви, эллюви, делюви, пролюви, мөсдлийн хурдсууд Хэнтийд өргөн тархсан байдаг. Неоген, дөрөвдөгчийн хурдсууд уулс хоорондын хотгор, хонхор, голуудын хөндийг дүүргэсэн байдгаас гадна төвийн өндөр уулсын хавьд зарим хэсэгтээ аллювийн хурдас, дөрөвдөгчийн өмнөх үеийн хурдас алаг цоог тархана.

2.3 Гадаргын ус

Усзүйн хувьд Хойд мөсөн далайн ай савын Туул голын ай савд багтах бөгөөд олон жилийн дундаж урсац нь 100м-ээс илүү бүс нутагт хамаарна.

Туул гол нь эхэндээ (эхээс 170 орчим км) олон тооны гол горхи, булаг ихтэй бөгөөд Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Хийд, Хаг, Зүүн баян, Тэрэлж, Улиастай, Сэлбэ зэрэг голууд цутгах ба харин голын уртын дагуугийн үлдэх ихэнхи доод хэсэгт Түргэн, Харбух, Тосон зэрэг цөөн тооны жижиг гол горхиуд цутгана. Голын ус хурах талбай 49900 км', урт нь 874 км, ус хагалбарын шугамын урт 2055,6 км, ус хурах талбайн дундаж өндөр 1474 м, голдрилын ерөнхий хэвгий 13% юм. Туул голын савд гол, горхины сүлжээний нягтшил дунджаар 0.39 км/км2, хэсэглэн авч үзвэл голын эх Гачуурт хүртэл 0.54 км/км2, Гачууртаас Лүн 0.1 км/км2, Лүнгээс Заамарын алтны бүс Орхон Туулын бэлчир хүртэл 0.05 км/км2 байна. Туул голын өргөн нь үергүй үед 35-75 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0,50-1.50 м/с, эргийн өндөр 0,5-2,5 м байдаг./Эх сурвалж: Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Усны нэгдсэн менежмент, Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл, УБ, 2012/ Туул голын ус хэмжилтийн Улаанбаатар харуулын урсцын ажиглалтын мэдээнд (1945- 2008) тулгуурлан жил бүрийн зарцуулгаар Туул голын тэжээлийг тогтоох урсацын гидрографын задлан ялгалт хийсэн дүнгээс үзвэл олон жилийн дунджаар хайлсан цас, мөсний ус 10.2%-ийг, газар доорх ус хөрсний усны тэжээл 17.65%, хур бороony ус 72.15% тус тус эзэлж байна.

2.4 Хөрсөн бүрхэвч

Налайх хот нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хэнтийн иж мужийн Хэнтийн баруун дэд мужид ойт хээрийн бүсэд оршдог. Газарзүйн байршлын хувьд нийслэлээс зүүн урагш 36 км зайд нийслэлийн Баянзүрх дүүрэг, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумтай хиллэдэг. Газар нутгийн хувьд нийт 68,7 мянган га газар нутагтай. 2016 оны тоо баримтаар 9108 өрхийн 35813 хүн амтай, засаг захиргааны 7 хороо, 40568 тоо толгой

малтай. Нийслэл хоттой авто болон төмөр замаар холбогдсон. Алт, цагаан тугалга, олор, нүүрс, шохой, элс хайрга зэрэг байгалийн баялагтай.

Төслийн талбай нь Налайх хот орчмын бүс нутаг нь газрын гадаргын хувьд Богд уулын системд харьяалагдах Налайх орчмын хаяа уулсын системд хамаарагдах нам уулсын системд байрлана. Тус судалгааны талбай нь хөрс газарзүйн мужлалаар хөрс-био уур амьсгалын их мужийн холимог бүсчлэл бүхий Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутаг хэв шинжийн Хэнтийн захын буюу 39-р тойрогт багтана. Уулын нугын болон уулын ойн ширэгт хөрс, ойн доод хил орчмоор уулын болон нугат хар хүрэн хөрс, уулсын бэл хажуу хэсгээр хар хүрэн, голын хөвөө орчмын өндөрлөг, төв татмын өндөрлөг газраар доод аллювийн ширэгт хөрс зонхилно.

2.5 Ургамлан бүрхэвч

БЦГ-ын нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ойн мужийн Өвөр байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрог, Евразийн хээрийн мужийн, Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрогт тус тус хамаарагдана (Юнатов, 1950). Гол нуруудад ойн дээд хил д.т.д. 2200 метрт орших ба түүнээс дээш төгрөг навчит хус, Сибирь болон хонин арц, алтан тэрэлж, тагийн хүйтсүү алаг өвс, зожир өвст бүлгэмдлүүд алаг цоог тархсан, нураг, асга элбэгтэй.

2.6 Амьтны аймаг

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрт 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй хөхтөн, суурин болон нүүдлийн 250 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 3 зүйл могой, 1 зүйл бах, 1 зүйл гүрвэл болон 16 зүйл загас тэмдэглэгдсэн байдаг. Эдгээрээс Туулын хөндий дэх Тэрэлжийн гүүр орчим шавьж идэштэнээс өөдсөн атигдаахай, бэсрэг царам, дааган, хонин атигдаахай, сарьсан далавчтанаас сахалт, соотон багваахай, туулай хэлбэртнээс чандага, дагуур болон асганы огодой, мэрэгчдээс урт сүүлт зурам, жирх, бор туулай, хэрэм, махан идэштэнээс саарал чоно, шар үнэг, дорго, цагаан үен, туурайтнаас зэрлэг гахай, шувуудаас хээрийн галуу, ангир, бүх төрлийн нугас, шаазгай, болжморууд зэрэг амьтад нутагшсан байна. Ойгоор бүрхэгдсэн ойн нийт талбайн 63.6 %-ийг эзэлж буй Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хувьд ой мод экологийн чухал ач холбогдолтой бүрэлдэхүүн хэсэг, ихээхэн нөлөө бүхий байгалийн хүчин зүйлс болох нь илэрхий байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү бүлэгт төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд түүнд өртөх газрын гадарга агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхой тусгана.

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллахаас гадна химийн бодисын онцлог шинж чанар, хор аюул, хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт талаар ажиллагсдад мэдлэг олгож, болзошгүй сөрөг нөлөөлөл, осол эрсдлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар дотоод дүрэм, журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Уг төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Тус төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусагдахуун нь агаар, хөрс, ус, газрын гадарга, ургамал юм.

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
1.	Энгийн хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол үүсэх. Хог хаягдал ил задгай хаях, хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйтгэл хийхгүй байх, тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс элдэв шавьж үржих, халдварт өвчиний эх үүсгэвэр болох	✓ Зориулалтын тусгай цэг тохижуулах ✓ Тогтсон хугацааны давтамжтай, тогтмол ачин зайлуулах ✓ Хогийн цэгт байнга ариутгал халдваргүйжүүлэлт хийх ✓ Зориулалтын бус газарт шатааж агаар орчин бохирдуулахгүй байх ✓ Ил задгай хаяж орчныг бохирдуулахгүй байх ✓ Эх үүсвэр дээр нь ангилан ялгах ✓ Дахиварыг хэрэглэгч байгууллагад дахин боловсруулахаар шилжүүлэх
2.	Тээврийн хөдөлгөөн ихсэх, хөрс, ургамал талхагдах	✓ Орчны хөрсийг тогтмол цэвэрлэх, нөхөн сэргээх, зүлэгжүүлэх, мод тарих, ✓ Тогтоосон замыг засаж сайжруулах, тэмлэглэгээ хийх, явган хүний зорчих замыг хийж тохижуулж, асфальтаар хучих зэрэг арга хэмжээ авах
3.	Химийн бодисоор агаар ус, хөрс бохирдох	✓ Агуулахын агааржуулалтын ажиллагааг байнга хянаж хэвийн ажиллагаатай байлгах, агааржуулалтын систем мембран шүүлтүүртэй байх, тогтмол хугацаанд солидог байх. ✓ Бодис хадгалах савыг битүүмжлэл сайтай байлгах ✓ Хадгалах, тээвэрлэх, худалдаалах, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны заавар боловсруулан мөрдөж ажиллах ✓ Агуулахыг хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах ✓ Бодисын хор аюулын талаарх мэдээлэл, танилцуулах самбар тэмдэг тэмдэглэгээг агуулахад ил байршуулах ✓ Химийн бодистой холбоотой сургалт семинар байнга

		зохион байгуулах ✓ Гадаргын болон газрын доорх усанд алдахгүй байх
4.	Химийн бодисд өртөх, хүн амьтанд хортой аюултай нөлөө үзүүлэх	✓ Химийн ШУ, химийн бодисын талаар суралцсан мэргэжлийн хүн ажиллуулах ✓ Бодисын хор аюул, нөлөөллийн талаарх мэдээ мэдээлэл өгөх сургалт байнга зохион байгуулах ✓ Байгальд ил задгай хаяхгүй байх ✓ Бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгөх ✓ Зааварчилгаа, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих
5.	Химийн бодисоор бохирдсон хортой, аюултай хог хаягдал гарах	✓ Аюултай хог хаягдал үүсгэгчийн код авах ✓ Хог хаягдлын тухай хуулийг мөрдөж ажиллах ✓ Химийн бодисын сав баглаа боодлыг худалдан авагч нараасаа тоо ширхэгээр нь буцаан татан авч түр хадгалах. ✓ Аюултай хог хаягдал цуглуулж түр хадгалах тусгай цэг, хадгалах агуулах бий болгож хяналттай байлгах ✓ Химийн бодисоор бохирдсон материал, эд зүйл, хугацаа дууссан бодис урвалж зэрэг аюултай хог хаягдлыг ангилан хадгалах ✓ Бохирдсон бүх зүйлийг тусгайлсан хогийн цэгт түр хадгалах Аюултай хог хаягдлыг хуульд заасны дагуу хэмжээнээс хамааран 90 хоног хүртэл хадгалах ✓ Эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай эрх шилжүүлэх гэрээ хийх, дагалдах маягт бүртгэлийг хөтлөж бүртгэх ✓ Эрх шилжүүлэхдээ дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах ✓ Аюултай хог хаягдлын тайланг жил бүрийн 11 сард гаргаж харъяа дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст албан тоотор хандан хүргүүлэх Дээрх үйл ажиллагаануудын хууль эрх зүйн үндсийг доор тусгав. Үүнд: ✓ Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ ✓ Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам /2018, 116-р тогтоол 1 дүгээр хавсралт/

6.	Химийн бодисын тээвэрлэлт, түүнтэй холбоотой аюул эрсдэл гарах /гэнэтийн осол аваарь, техникийн бүрэн бус байдал, жолоочийн хариуцлагагүй байдал/	✓ Байгууллагын “Химийн ослоос урьчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө”-нд тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайтар нарийн тусгаж, химийн бодис тээвэрлэлтийн маршрутаа батлан хавсаргах ✓ Тус төлөвлөгөөнд “Бодисын асгаралт бага үед авах арга хэмжээ, саармагжуулах арга”, “Бодисын асгаралт их үед авах арга хэмжээ, саармагжуулах арга”-ыг тус тус нарийвчлан тусгаж өгөх, харъяа дүүргийн ОБГ-аар шинэчлэн хянуулж батлуулах. ✓ Тогтоосон маршрутаас ангид тээвэр хийхийг хатуу хориглох ✓ MNS 4978:2017 Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг хийх ✓ Аюултай ачаа тээвэрлэх тусгай зөвшөөрөл авах ✓ Дадлага туршлагатай тээврийн ангилалд нийцсэн жолоочийг химийн бодисын аюул эрсдэлээс сэргийлэх сургалтад хамруулсны дараа химийн бодисыг тээвэрлэх тээвэрт явуулах ✓ Өөрсдөө тээвэр хийх боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл бүхий тээвэрлэлтийн компаниар тээвэрлэлтийг гүйцэтгүүлэх.

3.1 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

- Химийн бодисын хадгалалтын явцад тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэл болон химийн бодис хадгалах шаардлагын дагуу хадгалаагүй, хамт хадгалах хориотой бодисын хамт хадгалсан тохиолдолд химийн бодис асгарах, алдагдах зэргээр агуулахын дотоод орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөл үүснэ.
- Химийн бодисыг хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөж, тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах эрсдэлтэй
- Химийн бодис тээвэрлэх машины тоног төхөөрөмж, ялангуяа дизель түлшээр ажилладаг хүнд даацын машин, техникийн хорт утаа ялгарах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.
- Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх шаардлагыг дагаж мөрдөөгүй, химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу тээвэрлээгүйн улмаас тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдох зэргээр химийн бодис алдагдах, химийн бодисууд урвалд орох, галын аюул гарах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

3.2 Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

- Химийн бодисын хадгалалтын явцад тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэл болон химийн бодис хадгалах шаардлагын дагуу хадгалаагүй, хамт хадгалах хориотой бодисын хамт хадгалсан тохиолдолд химийн бодис асгарах, алдагдах зэргээр агуулахын дотоод орчны усан орчинд сөргөөр нөлөөлнө.
- Химийн бодисыг хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих, халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөж, тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах эрсдэлтэй.
- Химийн бодис тээвэрлэх /машины тоног төхөөрөмж, ялангуяа химийн бодис ил задгай сав баглаа боодол эвдэрч гэмтсэн/ үед цас бороонь усаар угаагдан норж машины тэвш, газарт химийн бодис үлдэх зэргээр хөрс, гадаргын болон гүний усны чанарт сөргөөр нөлөөлнө. Гэхдээ энэ нь түр зуурын тархмал шинж чанартай байна.
- Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдох зэргээр химийн бодис алдагдах, химийн бодисууд урвалд орох, газрын гадарга болон доорх усны чанарт сөргөөр нөлөөлнө.

3.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Химийн бодисын хадгалалтын явцад тухайн бодисын Хор аюулын лавлах мэдээлэл болон химийн бодис хадгалах шаардлагын дагуу хадгалаагүй, хамт хадгалах хориотой бодисын хамт хадгалсан тохиолдолд химийн бодис асгарах, алдагдах зэргээр агуулахын дотоод орчны хөрсний чанарт сөргөөр нөлөөлнө.
- Химийн бодис тээвэрлэх /машины тоног төхөөрөмж, ялангуяа химийн бодисыг ил задгай тээвэрлэх, сав баглаа боодол нь эвдэрч гэмтсэн/ үед цас бороонь усаар угаагдан норж машины тэвш, газарт химийн бодис үлдэх зэргээр хөрсний чанарт сөргөөр нөлөөлнө. Гэхдээ энэ нь түр зуурын тархмал шинж чанартай байна.
- Химийн бодисыг тээвэрлэх ба тээвэрлэлтийн явцад тооcжилт үүсэх, Хамгаалалтын сахиул айл, агуулахын байр талбай, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.
- Агуулахын ажилчдын байр, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс

бохирдоно.

- Химийн бодисыг ачиж, буулгах үед аюулгүй ажилгааны дүрмийг баримтлаагүйн улмаас хөрсөн дээр асгарах, хөрсөн бүрхэвч бохирдох

3.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Ургамлын бичил орчин өөрчлөгдсөнөөс нутгийн унаган ургамалшилтад өөрчлөлт орж, хогийн ургамлын төрөл зүйл ихсэх магадлалтай.
- Агуулахын үйл ажиллагаа, автомашины замын тоос зэрэг нь ойр орчмын агаарыг тоосжуулахаас гадна, ургамлын навч эрхтэнд шороон тоос цугларч ойр хавийн ургамлын цаашдын амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Ургамлын ургац ашиглалт явуулж буй хэсэгт бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхагдаж орсон хэсэгт хогийн ургамал ялангуяа шарилж ихээр ургаж хүн амьтны амьсгалд тоосны аллерги үүсэх үндэстэй
- Машин техник хэрэгслийн түлш шаталтын дүнд үүссэн хорт хийд агуулагдаж буй NOx болон SOx тунадастай хамт юмуу хатуу тоос хэлбэрээр ургамлан бүрхэвч дээр бууж цааш хөрсөөр дамжин тархан ургамал, амьтанд сөргөөр нөлөөлөх.

3.5 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

- Химийн бодис тээвэрлэх, ажилчид ажилдаа явах үед машинд дайрагдах, дуу шуугиан, тоос шорооны улмаас ихэнх хөхтөн амьтад дайжин үргэх зэргээр нөлөөлнө.
- Хүнд, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн, янз бүрийн таагүй үнэр, гэрэл эрс нэмэгдэж тухайн нутаг болон орчны бүс дэхь амьтдын тайван байдал алдагдаж, дүрвэн зайлж байршил нутгаа өөрчилнө.
- Тоосжилтоос орчны бэлчээрийг бохирдуулж мал болон өвсөн тэжээлт амьтдыг ямар нэг хэмжээгээр хордуулна. Машин техник олшрох тутам орчны хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн талхигдал ихсэж амьтад амьдрах боломжгүй болно.
- Техникийн тос, шатахуун, янз бүрийн хаягдалд амьтад хордож үхэх, тэдгээрийг идсэн махчин амьтад хордоно.Хөрсний бичил биетэн, шавж олноор устаж үгүй болно.

3.6 Хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны үед үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу болон стандартын дагуу хадгалаагүй улмаас тэсэрч, дэлбэрэх, урвалд орох, галын аюул гарснаар

ажилчдын эрүүл мэнд болон үйлдвэрийн эд хогшил, байгаль орчинд сөрөг нөлөөллийг үзүүлнэ

- Химийн бодисыг тээвэрлэн авчрахад хурд хэтрүүлэх, хөдөлмөр аюулгүй байдлын дүрмийг даган мөрдөж ажиллаагүйн улмаас осол аваар гарах, хүний амь нас эрсдэх эрсдэлтэй
- Хүний буруутай үйл ажиллагааны улмаас галын аюул гарах, осол аваар гарах, ХАБ дүрмийг даган мөрдөөгүй зэргээр хүний амь нас болон үйлдвэрийн эд хогшилд сөрөг нөлөөллийг үзүүлэх эрсдэлтэй
- Агуулахын ХАБ-ын дүрэм зорчих зэргээс үүдэн ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдалд эрсдэл учруулна.

3.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, хүчтэй шуурга) болоход гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж, ажиллагсдыг сургалтад хамруулж дадлагажуулах, эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг талбайд байрлуулах.
- Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглох.
- Ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах.
- Ажил олгогч нь ажилтнуудын ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.

3.8 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж

- Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь дам байдлаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болно. Иймд ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөл үүсэхээс сэргийлж агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дагаж мөрдөх.
- Ажилтан бүр ажил олгогчийн баталсан жагсаалтын дагуу хөдөлмөрийн нөхцөл, ажил, үүргийн онцлог тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдаж, тэдгээрийг хэрэглэх үүрэгтэй.
- Ажлын байрны аюулгүй ажиллагааны нөхцөлд байнга хяналт тавьж, осол аюул гарсан тохиолдолд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, холбогдох сургалтыг явуулах.

- Ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл болон тохижилтыг дээд зэргээр ханган, байнгын хяналт тавин ажиллах.
- Ажиллагсдыг ажилд ороход нь эмнэлгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлуулсан байх ба эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулахын зэрэгцээ эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Химийн бодис, импортлох хадгалах, худалдаалах” төслийн БОМТ-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав. БОМТ-ний хүрээнд авч хэрэгжүүлэхэд 9.680.000 зарцуулахаар байна.

Хүснэгт 9.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн

№	Зардлын ангилал	2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	3.800.000
2	Нөхөн сэргээлтийн зардал	500.000
3	Хог хаягдал	480.000
4	Удирдлага зохион байгуулалт	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1.050.000
6	ОХШХ	100.000
7	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх хуваарь	-
Нийт дүн		**5.930.000**

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Химийн бодис, импортлох хадгалах, худалдаалах” -ний төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 10. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө								
“Химийн бодис хадгалах тээвэрлэхтэй холбоотой агаар орчинд үүсэх сөрөг нөлөөлөл”	Агааржуулалтын системд гэмтэл, доголдол гарч, хадгалалтын горим алдагдах	Агааржуулалтын ажиллагаа хэвийн байгаа эсэхэд урьдчилсан шалгалт үзлэг тогтмол хийх	төг	Агуулахын аюулгүй ажиллагаатай холбоотой тогтмол бүртгэл хөтлөх Дотоод зардлаар төлөвлөх	2026 он		Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Агаарын тухай" болон MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"	
	Ууршимтгай болох хуурай химийн бодисын битүүмжлэл алдагдан хугацаа алдсанаар гадаад орчинд тархах	Химийн бодисыг хадгалах явцад хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх, савны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгах, Орчны агаарын чанарын хяналт шинжилгээг хэрэгжүүлэх,	тогтмол төг	Орчны хяналт шинжилгээний зардалд тооцов.	2026 он			

	Машин техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, зориулалтын газар засвар үйлчилгээг тогтмол хийж	Шуугиан ихтэй техник, тоног төхөөрөмжүүд, түүнтэй харьцаж ажилладаг ажиллагсад орчин үеийн дэвшилтэт агааржуулалтын системийг сонгон авах	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд	2026 он	MNS 6768 : 2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө						
Асгаралтын иж бүрдэл ашиглах	Шатах тослох материал асгарсан тохиолдолд асгаралтын иж бүрдэл байршуулах	Агуулахын дотор байршуулах	1ш	500.000	2026 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”
						UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт
						MNS ISO22320:2020
Тээвэрлэлтээс хөрс, газрын гадарга эвдрэх	Зам болон хөрс газрын хэвлийг эвдрэлд оруулахгүй байх бүх талын арга хэмжээг авах, үерийн хамгаалалтын далан, суваг шуудуу байгуулах	Агуулахын гадна талд	төг	1.500.000	2026 он	UCS 0501B:2023 БОАЖ-ын сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ					
Бохирдлын эх үүсвэр шатах тослох материал, ахуйн бохир ус болно. гадаргын болон газрын доорх усыг шууд, шууд бусаар бохирдуулах	Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Төслийн хэрэгжиж буй Ус хэмнэх	тогтмол	Ус хуримтлуулах сав поошиг тавих 300.000 төгрөг	MNS 4586: 1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага “Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
Гадаргын болон гүний усны эх үүсвэр бохирдох	Газрыг тэгшилж, хур борооны ус, чийг шүүрч нэвчихээс сэргийлж гадаргын урсац зайлуулах насос тавих	Төслийн талбай	тогтмол	1.500.000	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө					
Зам ашиглалт, тоосжилтоос шалтгаалан замын дагуух ургамал нөмрөг доройтох .	Орчны ургамлан бүрхэвч устах, талхлагдах, олон салаа зам гарахаас сэргийлэх, чөлөөт зорилтыг хязгаарлах арга хэмжээ авах	Төслийн талбай доторх	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан болно.	2026 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж
	Замын хажуу хэсгийн ургамлыг аль болох сүйтгэхгүй байх. Машин техник тоног төхөөрөмж зөвхөн төлөвлөсөн замын дагуу явах	Төслийн талбай	Үйл ажиллагааны хүрээнд	2026 он	

	Химийн бодисыг ачиж, буулгах явцад хөрс, ургамлан бүрхэвч дээр химийн бодис асгахгүй байх							
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ								
Хөрсний бичил амьтад устаж дайжих	Хөрсөн орчны бохирдол ихэссэнээр хөрсний бичил биетнүүд багасах ба үүнээс сэргийлж ариутгал хийх	Төслийн талбай	1ш		300.000	300.000	2026 он	MNS ISO22320:2020
	Агуулах дотор хортон шавж орох, мэрэгчид үүрлэн үүрээ засахаас сэргийлж ариутгах	Төслийн талбай	Үйл ажиллагааны хүрээнд				2026 он	MNS 5161-2 - 2002

Нийт дүн: 3.800.000

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11.Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн талбайн хашааг дагуулж мод тарих	*шар хуайс, монос, голт бор, долоогоно, чацаргана г.м* тарьж ургуулах	Төслийн талбай	ш	50	10000	500.000	2026 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008;

Нийт дүн: 500.000

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл	Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж)	Төслийн талбайн ажилчдад	Дотоод зардалаар төлөвлөх			2026 он	MNS 4990: 2015 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”
	Төслийн ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцасаар тогтмол хангаж ажиллах	Төслийн талбайн ажилчдад хэсэгт	3	350.000	1.050.000	2026 он	MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”;
Үйл ажиллагааны явцад ажиллагсад осол, аваарт өртөж болзошгүй	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм журмуудыг бүрэн боловсруулж мөрдүүлэх, курс, сургалтын болон зааварчилгаа өгөх ажил зохион байгуулах	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны хүрээнд			2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Сургалтын хөтөлбөр
	Осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны хүрээнд			2026 он	
Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аваарт өртөх	Гал түймрээс хамгаалах багаж хэрэгслийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах	Агуулахад	Дотоод зардлаар төлөвлөх			2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, /шинэчилсэн найруулга/ 2017 он; MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага”
	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох лоом, хүрз, сүх, хөрөө, хувин, хоолой, багор дэгээ, жоотуу, тармуур, хөөс, хорны суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланг зэргийг бэлэн байлгах,	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны хүрээнд			2026 он	

Нийт дүн: 1,050,000

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хууль	2026 он	Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явцад			Тухайн үед нь шийдвэрлэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэглээний норм, гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 14. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хог хаягдлын менежментийг зохистой төлөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх буюу 3R зарчмыг баримтлан ажиллах	Төслийн талбай	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			2026 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”

	Хатуу шингэн хог хаягдлыг графикийн дагуу тогтмол ачуулж байх	Төслийн талбай	40.000* 12=480.000		2026 он	Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, 8.1.7а, 8.1.7.б, 8.1.7.г, 8.1.9, 8.1.9.а-д
	Бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулах	Төслийн талбай	тогтмол	Үйл ажиллагаа төслийн хүрээнд	2026 он	
Химийн бодисын аюултай хог хаягдал	2026 онд нийлүүлэх химийн бодисоос гарах хог хаягдал	Буцаан таталт	тогтмол	Цууны хүчил 624 ш канистер, 1120 ш шуудай, 1120ш шуудай, 4800ш шуудай хог хаягдал эргүүлэн татна. Гарах зардлын төлбөрийг дотоод төлөвлөлтөөр шийднэ.	2026 он	
						Нийт дүн: 480.000

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь “Химийн бодис, импортлох хадгалах, худалдаалах” төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Бид 2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон давтамжийг тусгалаа.

Хүснэгт 15. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг

Ялгарах бохирдуулагчид: SO2, CO, NO2	Төслийн талбайд 2 байршилд	Жилд 1 удаа буюу 10 саруудад дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө	1 удаа	55.000	55.000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	2026 он	MNS 4585:2016,
Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тооссжилт зэрэг морфологи тогтцын өөрчлөлтийг хянах	Төслийн талбайд 1 байршилд	Төслийн талбайд	1 удаа	45.000	45.000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	2026 он	MNS 5850:2019,
								Нийт дүн: 100.000

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 16. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	**Урьдчилан тооцсон төсөв**	**Хэрэгжүүлэх хугацаа**			**Хариуцсан албан тушаалтан**	**Тайлбар**
		2026 он				
		Сар	Сар	Сар		
Ажилчдад аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулж байх;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Улирал бүр			"Ундрах гарц” ХХК Захирал	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй” MNS ISO 13688: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас-Ерөнхий шаардлага
Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Жилд 1 удаа			"Ундрах гарц” ХХК Захирал	
Тухайн жилийн БОМТөлөвлөгөөг батлагдсан журмын дагуу жил бүр боловсруулан БОУАӨЯ-аар батлуулах;	Дотоод төлөвлөлтөөр	2026 он			"Ундрах гарц” ХХК Захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Ажилчдад аюултай хог хаягдлын талаарх сургалтыг дотоодоо явуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	2026 он			"Ундрах гарц” ХХК Захирал	Хог хаягдлын тухай хууль

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 17. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Химийн бодис импортлох хадгалах, худалдаалах төслийн БОМТ БОХ-ыг таниулах, мэдээлэх, тус багийн оршин суугчдад таниулах	Цаасан хэлбэрээр	Төлөвлөгөөт Ажлын тайлан, Биелэлтийн үр дүн, Дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 дугаар сард	Дотоод төлөвлөлтөөр	"Ундрах гарц” ХХК Захирал	"Ундрах гарц” ХХК
Химийн бодис импортлох хадгалах, худалдаалах төслийн харьяаллын сумын ИНХ,	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга	Төлөвлөгөөт Ажлын тайлан, Биелэлтийн үр дүн, Дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	Дотоод төлөвлөлтөөр	"Ундрах гарц” ХХК Захирал	Хорооны ИНХ-н танхимд